



АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



2025 он

АГУУЛГА

1. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН	2
1.1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	2
1.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	4
1.3. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	5
1.4. САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	6
2. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	7
3. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ.....	16
3.1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....	16
3.2. ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ	17
3.3. ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ.....	17
3.4. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ.....	17
4. БУСАД ТАЙЛАН.....	18
4.1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ 18	
4.2. ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ	20
4.3. УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	21
4.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
5. ДҮГНЭЛТ	24
6. ЗӨВЛӨМЖ.....	26
7. ХАВСРАЛТ	27

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” зэргийг тус тус баримтлан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны байгууллагын үйл ажиллагаанд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөв.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны үйл ажиллагаа, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний нэгтгэсэн тайланд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, Салбарын нийгэм, эдийн засгийн үзүүлэлт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, Байгууллагын ил тод байдлын үнэлгээнд тулгуурлан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 3 багц, 7 үзүүлэлтээр дүгнэв.

Түүнчлэн Аймгийн засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт, Гадаадын зээл тусламжийн санхүүжилтээр салбарт хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт, Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт болон бусад тайлангуудыг оруулан тайлагнав.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2024 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад ерөнхий үнэлгээ **84.98%** буюу **4.25** оноотой байна.

1. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

1.1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2024 оны жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 217 шийдвэрийн 439 зүйл, **заалтыг** салбар чиглэлээр ангилж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **78.2** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

Нийт 217 шийдвэрийн 439 зүйл, заалтаас 39 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй хэрэгжилтийг дүгнэсэн 400 зүйл, заалтын 224 зүйл, заалт “бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй, 100 зүйл, заалт “хэрэгжих шатанд” 70 хувийн биелэлттэй, 60 зүйл, заалт “хэрэгжилт хангалтгүй” 30 хувийн биелэлттэй, “хэрэгжээгүй” 0 хувийн биелэлттэй 15 зүйл, заалт байна.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ /Хууль тогтоомжийн төрлөөр/

	Нийт	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	217	7	24	19	2	77	79	4	2	3	-	-
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	439	17	70	58	2	92	170	21	2	7	-	-
Бүрэн хэрэгжсэн	224	14	30	22	2	53	92	4	2	5	-	-
Хэрэгжих шатанд	100	3	9	13	-	25	41	8	-	1	-	-
Хэрэгжилт хангалтгүй	60	-	23	11	-	6	14	5	-	1	-	-
Хэрэгжээгүй	15	-	1	7	-	-	6	1	-	-	-	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	40	-	7	5	-	8	7	3	-	-	-	-
Биелэлтийн дундаж	78.20	94.71%	68.57%	64.91%	100%	86.07%	81.63%	61.67%	100%	85.71%	-	-

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- МУ-ын 7 хуулийн 17 заалтын хэрэгжилт 94.71%
- УИХ-ын 24 тогтоолын 70 заалтын хэрэгжилт 68.57%
- УИХ-ын байнгын хорооны 19 тогтоолын 58 заалтын хэрэгжилт 64.91%
- Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 2 заалтын хэрэгжилт 100%
- Засгийн газрын 77 тогтоолын 92 заалтын хэрэгжилт 86.07%;
- Засгийн газрын хуралдааны 79 тэмдэглэлийн 170 заалтын хэрэгжилт 81.63%;
- Засгийн газрын 4 албан даалгаврын 21 заалтын хэрэгжилт 61.67%
- Ерөнхий сайдын 2 захирамж 2 заалтын хэрэгжилт 100.0%
- ҮАБЗ-ийн 3 зөвлөмжийн 7 заалтын хэрэгжилт 85.71%

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг яамны удирдлагын зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 08 дугаар хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1380 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулан баталгаажуулав.

1.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 16 зорилтын 75 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хяналтад авсан 75 арга хэмжээний 55 арга хэмжээг тус яам толгойлон, 20 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба хэрэгжилт **69.6** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,
- Эдийн засгийн бодлогын хүрээний 11 зорилтын 70 арга хэмжээний биелэлт 67.4 хувь,
- Засаглалын бодлогын хүрээний 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,
- Ногоон хөгжлийн бодлогын 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 100.0 хувь, хэрэгжүүлсэн нийт 75 арга хэмжээний биелэлтийг **69.6** хувьтай дүгнэлээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО /2024 оны жилийн эцсийн байдлаар/

Зорилго	Зорилтын тоо	Арга хэмжээн ий тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо							Хэрэгжилт /хувь/
			100	90	70	50	30	0	х/б	
Нэг. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	1	1	1	-	-	-	-	-	-	100
Хоёр. Эдийн засгийн бодлого	11	70	28	10	3	6	17	6	-	67.4
Дөрөв. Засаглалын бодлого	2	2	2	-	-	-	-	-	-	100
Тав. Ногоон хөгжлийн бодлого	2	2	2	-	-	-	-	-	-	100
Дүн	16	75	33	10	3	6	17	6	-	69.6

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 2024 оны 12 дугаар сарын байдлаар **69.6 хувьтай** дүгнэгдсэн бөгөөд 33 арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрч 100 хувийн гүйцэтгэлтэй, 10 арга хэмжээ гол үр дүн гарч эхэлж байгаа буюу 90 хувь, 3 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувь, 6 арга хэмжээ ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувь, 23 арга хэмжээ боловсруулалтын шатанд буюу 0-30 хувь буюу үр дүнгүй, тогтоол, шийдвэрээр зогсоосон хэрэгжих боломжгүй 1 арга хэмжээ байна.

1.3. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 3 зорилгын 15 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үнэлгээг 2024 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /unelgee.gov.mn/ цахим системд байршуулсан 1 зорилтын 15 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилгоор нь авч үзвэл:

- 2.2.Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ гэсэн зорилгын хүрээнд хяналтад авагдсан 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан ба биелэлт 72.66 хувьтай (хүснэгт №1) үнэлэгдлээ.

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Зорилго	Арга хэмжээний тоо	Үнэлгээ (хувь)					Хэрэгжилт (хувь)
		100	90	70	30	0	
2.2.Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	15	3	5	4	2	1	72.66
Нийт дүн	15	3	5	4	2	1	72.66

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар **72.66** хувьтай дүгнэгдэж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулж баталгаажуулав.

1.4. САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийв.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд геологийн зураглал, голлох эрдэс түүхий эдийн олборлолт, экспорт, газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 6 ангиллын 18 үзүүлэлтээр дүгнэхэд тайлант хугацаанд 8 үзүүлэлт зорилтот түвшинд хүрсэн буюу давж биелсэн бол үлдсэн 10 үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй, үзүүлэлт буурсан гүйцэтгэлтэй байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 2024 оны жилийн эцсийн байдлаар “тодорхой үр дүнд хүрсэн” буюу **94.8** хувьтай, **4.7** оноогоор дүгнэгдлээ.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ	
			2020	2024	2024	Хувь	Оноо
1	Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн 1:50 000-ын масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдалт (хувь)	хувь	41.1	47.0	47.0	100.0	5.0
2	Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн 1:200000-ын масштабын иж бүрэн зураг нэгтгэх төслийн хэрэгжилт (бүх нутгийг хамарсан байх)	хувь	30.0	100.0	100.0	100.0	5.0
3	Голлох эрдэс түүхий эдийн олборлолтын хэмжээ						
	Газрын тос (мян.бар)	бар	4,199.1	4,850.0	4,188.3	86.4	4.3
	Нүүрс (сая тн)	сая тн	38.0	80.0	97.7	122.2	5.0
	Зэсийн баяжмал (мян.тн)	мян.тн	1,270.0	2801.0	1,562.2	55.8	2.8
	Төмрийн хүдэр (сая тн)	сая тн	8.2	10	10.1	101.1	5.0
	Алт (тн)	тн	19.0	24.0	16.5	68.6	3.4
4	Голлох эрдэс түүхий эдийн экспортын хэмжээ						
	Газрын тос (мян.бар)	бар	4,198.8	4,800.0	4,067.6	84.7	4.2
	Нүүрс (сая тн)	сая тн	25.0	50.0	83.8	167.5	5.0
	Зэсийн баяжмал (мян.тн)	мян.тн	1,270.0	2,801.0	1,695.4	60.5	3.0
	Төмрийн хүдэр (сая тн)	сая тн	8.2	10	7.5	75.1	3.8
	Алт (тн) Монгол банканд тушаасан	тн	19.0	24.0	11.6	48.5	2.4
5	Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ						
	Үүнээс: ОХУ-аас	сая тн	1.9	2.29	2.63	114.8	5.0
	Бусад улсаас	сая тн	0.1	0.11	0.09	81.5	4.1
6	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл (тн)						
	Катодын зэс 99%	тн	9,300.0	11,800.0	9,661.2	81.9	4.1
	Цахилгааны утас	тн	72.0	80.0	70.2	87.8	4.4
	Метал бэлдэц	тн	15,507.0	35,350.0	37,680.5	106.6	5.0
	Метал цувимал	тн	16,675.0	33,000.0	36,117.9	109.4	5.0

УУХҮЯ-ны ЭЗНХҮ-ийн биелэлтийн ерөнхий үнэлгээ	94.8%	4.7
---	-------	-----

2. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.1 БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 8 зорилгын 21 зорилтын 142 арга хэмжээний жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг дараах байдлаар үнэлэв. Үүнд:

- Зорилго 1. “Нутаг дэвсгэрийн 2-20%-ийг геологийн судалгааны ажилд хамруулан ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөж, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2022 онд 20.8 их наяд төгрөг байсныг 2023 онд 30.5 их наяд төгрөг болгон нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийг 2024 онд 9.7 хувьд хүргэж, газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2024 онд 626 мян.тн-д хүргэнэ” гэсэн зорилгын хүрээнд 8 зорилт 61 арга хэмжээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **86 хувь**;
- Зорилго 2. “Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2022 онд 71.48 хувь байгааг 2024 онд 85 хувьд хүргэнэ.” гэсэн зорилгын хүрээнд 1 зорилт 7 арга хэмжээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт – **80 хувь**;
- Зорилго 3. “Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэж, яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2022 онд 71.48 хувь байгааг 2024 онд 85 хувьд хүргэнэ” гэсэн зорилгын хүрээнд 2 зорилт 25 арга хэмжээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **96.6 хувь**;
- Зорилго 4. “Салбарын хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2023 оны түвшингээс бууруулахгүй байх арга хэмжээ авна.” гэсэн зорилгын хүрээнд 2 зорилт 11 арга хэмжээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **99.4 хувь**;
- Зорилго 5. “Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа 2012 онд 47.5 хоног байгааг 2024 онд 25 хоногт хүргэнэ.” гэсэн зорилгын хүрээнд 4 зорилт 21 арга хэмжээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **99.7 хув** ;
- Зорилго 6. “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичигт салбарын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга

хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт зөвлөмж гаргах, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллана.” гэсэн зорилгын хүрээнд 2 зорилт 3 арга хэмээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **100 хувь**;

- Зорилго 7. “Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах.” гэсэн зорилгын хүрээнд 1 зорилт 11 арга хэмээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **54.5 хувь**;
- Зорилго 8. “Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу эрсдэлд суурилсан хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулна” гэсэн зорилгын хүрээнд 1 зорилт 4 арга хэмээний биелэлт гарсан бөгөөд хэрэгжилт- **92.5 хувь**.

БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

Зорилго, зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц /хувиар/							Үнэлгээ /%/
		100	90	70	50	30	0	/-/	
Зорилго 1. Нутаг дэвсгэрийн 2-20%-ийг геологийн судалгааны ажилд хамруулан ашигт малтмалын нөөц, баялгийн хэмжээг өсгөж, уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2022 онд 20.8 их наяд төгрөг байсныг 2023 онд 30.5 их наяд төгрөг болгон нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувийг 2024 онд 9.7 хувьд хүргэж, газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2024 онд 626 мян.тн-д хүргэнэ.									
1. АХ - 4.2.2.4, ШСБ-3.1.2, МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.3, УХЖТ-2.2.1.1. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	9	4	1	2	/-/	2	/-/	/-/	76.7
2. АХ-4.2.24, ШСБ-3.1.1, МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.4, УХЖТ-2.2.13. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.	/-/	/-/	/-/	2	/-/	/-/	/-/	/-/	70
3. АХ-4.2.24, ШСБ-3.1.1, МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.5, УХЖТ-2.2.1.2. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт,	3	3	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100

хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.									
4. ЗГҮАХ-3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ. ШСБ-ын 3.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн, эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулна.	19	13	/-/	4	1	/-/	1	/-/	84.2
5.ЗГҮАХ-3.2.2.Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	2	2	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
6. АХ - 4 . 2 . 2 4 , ШСБ-3.1.1, ЗГҮАХ-3.2.16. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.	3	3	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
7.ЗГҮАХ-3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.	8	3	/-/	3	1	/-/	1	/-/	70

8. ШСБ-3.3, ЗГҮАХ-3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.	15	9	2	2	1	1	/-/	/-/	86.7
Дүн	61	37	3	13	3	3	2	/-/	86
Зорилго 2. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2022 онд 71.48 хувь байгааг 2024 онд 85 хувьд хүргэнэ.									
1. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож сайжруулна.	7	3	/-/	3	1	/-/	/-/	/-/	80
Дүн	7	3	/-/	3	1	/-/	/-/	/-/	80
Зорилго 3. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг хүнд сурталгүй, ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэж, яамны үйл ажиллагааны үнэлгээний түвшинг 2022 онд 71.48 хувь байгааг 2024 онд 85 хувьд хүргэнэ.									
1. Салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	22	19	1	/-/	/-/	2	/-/	/-/	93.2
2. Уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ.	3	3	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Дүн	25	22	1	/-/	/-/	2	/-/	/-/	96.6
Зорилго 4. Салбарын хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, зохицуулах, тайлагнах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2023 оны түвшингээс бууруулахгүй байх арга хэмжээ авна.									
1. Салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, статистикийн мэдээлэл, судалгаа шинжилгээний ажлын чанар, хүртээмжийг сайжруулна.	8	7	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	98.7
2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.	3	3	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100

Дүн	11	10	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	99.4
Зорилго 5. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа 2012 онд 47.5 хоног байгааг 2024 онд 25 хоногт хүргэнэ.									
1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	8	7	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	98.7
2. Салбарын хууль, эрх зүйн орчны давхардал хийдлийг арилгах, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно.	4	4	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
3.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын төсвийн гүйцэтгэл 2023 онд 93 хувь байсныг 2024 онд 2.0 хувиар нэмэгдүүлж, төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлнэ.	6	6	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
4.Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	3	3	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Дүн	21	20	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	99.7
Зорилго 6. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичигт салбарын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт зөвлөмж гаргах, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллана.									
1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийнэ.	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
2. Санхүүгийн болон үйл ажиллагааны дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллана.	2	2	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Дүн	3	3	0	0	0	0	0		100
Зорилго 7. Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах.									

Зорилт 1. Цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах.	11	6	/-/	/-/	/-/	/-/	5	/-/	54.5
Дүн	11	6	/-/	/-/	/-/	/-/	5	/-/	54.5
Зорилго 8. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу эрсдэлд суурилсан хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулна.									
1. Төрийн хяналт шалгалт болон геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, тайлагнах, хэрэгжилтийг хангуулна.	4	3	/-/	1	/-/	/-/	/-/	/-/	92.5
Дүн	4	3	/-/	1	/-/	/-/	/-/	/-/	92.5
Нийт дүн	142	104	6	16	4	3	7	/-/	87.3

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жилийн эцсийн байдлаар Төрийн захиргааны удирдлагын газраас нэгтгэн ирүүлсэн бөгөөд тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **87.3 хувийн** гүйцэтгэлтэй байна гэж дүгнэлээ.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 8 зорилгын 21 зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн 110 арга хэмжээ зорилтод түвшинд хүрч 90-100 хувийн гүйцэтгэлтэй, 20 арга хэмжээ үр дүн тодорхой хэмжээгээр гарч 50-70 хувийн гүйцэтгэлтэй, 5 арга хэмжээ боловсруулалтын буюу хэрэгжиж эхлэх шатандаа 30 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол 7 арга хэмжээ биелэлт хангалтгүй буюу үнэлэх боломжгүй байна.

2.2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4 дүгээр хавсралтаар төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан.

Тус журмын 6 дугаар хэсэг “Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, төрөл, арга зүй”-д нийцүүлэн хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх 3 зорилтын 8 үйл ажиллагаа, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 4 зорилтын 6 үйл ажиллагаа, нийт 14 шалгуур үзүүлэлтийн биелэлтэд үнэлгээг өгөв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр яамны Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг **98.6** %-тай дүгнэв.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны төсөвт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, шаардлагатай техник хэрэгслийг шинэчлэх, зэрэг дэв, цалингийн шатлал ахиулах, хоол унааны нэмэгдлийн төсвийг батлуулж хэрэгжүүлсэн байна

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх			
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	- Удирдлагын академийн богино хугацааны мэргэшүүлэх сургалтад 19 албан хаагч хамрагдаж сертификатаа авсан. - Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад -1 - Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5 - Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5 - Төрийн албан хаагчийн анх томилогдсон болон мэргэшүүлэх багц сургалтад 8 албан хаагч тус тус хамрагдан, сургалтаа амжилттай дүүргэн сертификатаа авсан. - Албан хаагчдын гадаад хэлний мэдлэг дээшлүүлэх сургалт 2 түвшинд нийт 44 албан хаагч - Монгол бичгийн сургалт дунд түвшний сургалтад 6 албан хаагч - Дотоод аудитын сургалт 2 албан хаагч - Жендерийн мэдлэг олгох сургалт 72 албан хаагч - БНХАУ-ын төрийн захиргааны албан хаагчийн мэргэшүүлэх сургалт 5 албан хаагч - Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжлийн сургалт 3 ажилтан - Худалдан авах ажиллагааны сургалт 11 албан хаагч - Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх сургалт 83 албан хаагч. - Салбарын мэргэшил дээшлүүлэх болон мэргэшсэн, зөвлөх инженерийн сургалтуудад 4 албан хаагчид хамрагдаж байна.	100
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	- Японы JDS хөтөлбөрт хамрагдаж 1 албан хаагч хууль зүйн ухааны магистрын чиглэлээр, Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөөр тэтгэлэгтэй суралцах сонгон шалгаруулалтад тэнцэн Австрали улсад суралцаж байгаа 1 албан хаагч амжилттай төгссөн байна. - Австралийн Засгийн газраас Төрийн байгууллагын бодлого тодорхойлох түвшний 2 албан хаагчдыг 30 хоногийн сургалтад хамруулсан. - БНХАУ-ын төрийн захиргааны албан хаагчийн мэргэшүүлэх сургалтад 5 албан хаагч хамруулсан.	100
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	Албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр худалдан авах ажиллагааны АЗ сургалт, архив бичиг хэргийн сургалт, монгол бичгийн сургалт, байгууллагын мэдээллийн цагаар жендер бодлого, гамшгийн бэлэн байдлын сургалт, ажлын байрны стрессийг даван туулах зэрэг хувь хүний хөгжилд чиглэсэн сургалтад зориулж 47.2 сая төгрөгийг зарцуулсан. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын 2 албан хаагчид Улсын их хурлын тамгын газар болон Зам тээврийн яаманд тус тус шилжин ажилласан.	100
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах			

4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2024.03.24-ны өдрийн 128, 2024.12.25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг тус тус шинэчлэн тогтоосон. Мөн төрийн үйлчилгээний албан хаагчдын доод хэмжээг дээрх тогтоолоор тогтоосныг яамны батлагдсан цалингийн төсөвт багтаан 20 хувиар нэмэгдүүлсэн. Түүнчлэн тухайн жилийн төсөвт тусгагдсан цалин хөлсний хэмнэгдсэн зардлаас ур чадвартай, өндөр үр дүнтэй ажилласан албан хаагчдыг жилийн эцсээр урамшуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/60 дугаар тушаалаар албан хаагчдад олгох өдрийн хоолны хөнгөлөлтийг 30,000, унааны хөнгөлөлтийг 3000 төгрөг болгон нэмэгдүүлсэн.	100
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/130 дугаар тушаалаар яамны төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг баталсан. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр боловсруулан баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд 2024 оны төсөвт тусгагдсан байрны цахилгааны монтаж шинэчлэх, компьютер, техник хэрэгслийн шинэчлэх, өрөөнүүдэд засвар, үйлчилгээ хийх, хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.	100
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Жил бүр албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх зорилгоор яамнаас нэгдсэн зохион байгуулалтыг хийж ирсэн. Гэрээний дагуу 2024 онд Сонгдо эмнэлэгтэй хамтран нийт албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулсан.	100
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр ажил олгогчоос дотоод журамд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламжид зориулан 57.6 сая төгрөг зарцуулсан. Түүнчлэн ажил олгогч албан хаагчдыг суралцах, ажиллах таатай нөхцөл боломжоор хангасан.	90
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН			98.6

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

д/д	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
1. Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	11 төрлийн сургалт	11	
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	4	4	

	албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт		Мэргэшүүлэх сургалт	5	5	
			Туршлага солилцох арга хэмжээ	3	3	
			Бусад	-	-	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	213	249 давхардсан тоогоор	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	95	114 давхардсан тоогоор	
			Эрэгтэй албан хаагч	118	135 давхардсан тоогоор	
			Удирдах албан тушаалтан	37	48 давхардсан тоогоор	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	176	201 давхардсан тоогоор	
		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	98%	
2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	4	
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	9	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	5	
			Эрэгтэй албан хаагч	-	4	
			Удирдах албан тушаалтан	-	2	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	7	
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	5%	
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	47.4	47.2	Тайлант оны гүйцэтгэлээр

		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	2.0	
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	52.8	52.3	Тайлант оны гүйцэтгэлээр
		4.2	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл /нэг өдөрт/ (мян.төг)	23.0	33.0	
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	97	
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	1	
		6.2	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	98	
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	135.7	135.4	Тайлант оны гүйцэтгэлээр

3. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

2.

3.

3.1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтын дагуу чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 10, хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 6, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 14, үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 2, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 12 нийт 44 үзүүлэлтээр хэрэгжилтийг гаргуулж, үнэлэв. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ил тод байдлын шалгуур

үзүүлэлтийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр нийт шалгуур үзүүлэлтүүдийг 93.7 хувийн биелэлттэй дүгнэв.

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

№	Нээлттэй мэдээлэл	Шалгуур үзүүлэлтийн оноо				Хэрэгжилтийн хувь
		МХБ	ХНБ	МБББ	ЭСТБ	
Нэг.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын						
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	30	30	30	30	100
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	30	30	30	30	100
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	30	30	30	30	100
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	30	30	30	30	100
1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	30	30	30	30	100
1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	30	30	30	30	100
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	30	30	30	30	100
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	30	15	30	30	87.5
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	30	15	30	30	87.5
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	30	30	30	30	100
Дундаж оноо, хувь		30	27	30	30	97.5
Хоёр.Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал						
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	30	30	30	30	100
2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	30	30	30	30	100
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	30	30	30	30	100
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	30	15	15	30	75
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	30	30	15	30	87.5
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	30	30	30	30	100
Дундаж оноо, хувь		30	27.5	25	30	93.7
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны						
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	30	30	30	30	100
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	30	30	30	30	100
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	30	30	30	30	100
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	30	15	30	30	87.5

3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	30	30	30	30	100
3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	30	30	30	30	100
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	30	30	30	30	100
3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	30	30	30	30	100
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	30	15	30	30	87.5
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	30	30	30	30	100
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт	30	30	30	30	100
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	30	15	15	30	75
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	30	15	30	30	87.5
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	30	15	15	30	75
Дундаж оноо, хувь		30	25.7	27.8	30	93.7
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн						
4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	30	30	30	30	100
4.2	Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	30	30	30	30	100
Дундаж оноо, хувь		30	30	30	30	100
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал						
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	30	30	30	30	100
5.5	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ,	30	15	15	30	75

	ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг					
5.6	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл	30	15	15	30	75
5.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	30	30	15	30	87.5
5.10	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл	30	15	15	30	87.5
5.13	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ	30	15	30	30	87.5
5.20	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	30	30	15	30	87.5
5.21	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	30	30	30	30	100
5.22	Албан тушаалтны Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар	30	15	15	15	54.1
5.23	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт	30	15	15	30	75
5.24	Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл	30	15	15	30	75
5.25	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	30	30	30	30	100
Дундаж оноо, хувь		30	21.2	20	28.7	83.7
Үнэлгээний ерөнхий оноо, хувь						93.7

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТ

2024 оны жилийн эцэс

№		Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1.	1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн цэсэнд болон мэдээллийн самбарт байршуулсан. https://shorturl.at/9Cv74 https://shorturl.at/rptGp https://shorturl.at/S4Wnm	100
2.	1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг цэсэнд байршуулсан. https://shorturl.at/9Cv74 https://shorturl.at/qChm3 https://t.ly/Dy-_Z	100
3.	1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж цэсэнд байршуулсан. https://t.ly/h6Gb4	100
4.	1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан цэсэнд байршуулсан. https://t.ly/wlGUa	100
5.	1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан цэсэнд байршуулсан. https://t.ly/dXqIN	100
6.	1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод,	100

			нээлттэй байдал цэсний үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт цэсэнд байршуулсан. https://t.ly/7ZH9W https://t.ly/IOtuO	
7.	1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг цэсэнд байршуулсан. https://t.ly/2Cvs0	100
8.	1.8	Өргөдөл, шийдвэрлэлтийн гомдлын тайлан, мэдээ	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ цэсэнд байршуулсан. https://t.ly/1kJeJ	87.5
9.	1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл цэсэнд байршуулсан. https://t.ly/M4EjO	87.5
10.	1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр цэсэнд байршуулсан. https://t.ly/bg12s	100
11.	2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл цэсэнд байршуулсан. https://t.ly/6lCJi	100
12.	2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам цэсэнд байршуулсан. https://t.ly/Q235E	100
13.	2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний албан хаагч,	100

			ажилтныг сонгон шалгаруулах журам цэсэнд байршуулсан. https://t.ly/R5qde	
14.	2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны ил тод байдал цэсний хүний нөөц цэсний хүний нөөцтэй холбоотой тушаал шийдвэр цэсэнд байршуулсан. https://t.ly/Qm92y	75
15.	2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ цэсэнд байршуулсан. https://t.ly/LbL74 https://t.ly/H1PCJ https://t.ly/fjVnP https://t.ly/l_tkV	87.5
16.	2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам цэсэнд байршуулсан. https://t.ly/iW6uU	100
17.	3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл цэсэнд байршуулсан. https://t.ly/Rwruw	100
18.	3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан цэсэнд байршуулсан. https://t.ly/YAKuE	100
19.	3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт цэсэнд байршуулсан. https://t.ly/FdAvS	100
20.	3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ цэсэнд байршуулсан. https://t.ly/PJgxv	87.5
21.	3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв,	100

			санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар цэсэнд байршуулсан. https://t.ly/w8qac	
22.	3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг цэсэнд байршуулсан. https://t.ly/J7NQC	100
23.	3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт цэсэнд байршуулсан. https://t.ly/1MC_F	100
24.	3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр цэсэнд байршуулсан. https://t.ly/bqU4e	100
25.	3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл цэсэнд байршуулсан. https://t.ly/yz7TH	87.5
26.	3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан цэсэнд байршуулсан. https://t.ly/g6jYv	100

27.	3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт цэсэнд байршуулсан. https://t.ly/nxVm_	100
28.	3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл цэсэнд байршуулсан. https://t.ly/ANQxb	75
29.	3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн цэсэнд байршуулсан. https://t.ly/QW11V	87.5
30.	3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан цэсэнд байршуулсан. https://t.ly/LVNYM	75
31.	4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал цэсний үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл цэсэнд байршуулсан. https://t.ly/uvQ8a https://t.ly/G_JMq https://t.ly/MuyoJ	100
32.	4.2	Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал цэсний зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа цэсэнд байршуулсан.	100

			https://t.ly/1tZfb https://t.ly/MPEcs https://t.ly/Gy10_	
33.	5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал цэсэнд байршуулсан. https://t.ly/Q1Vb6	100
34.	5.5	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг цэсэнд байршуулсан. https://t.ly/TdyJ6	75
35.	5.6	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл цэсэнд байршуулсан. https://t.ly/-9KaM	75
36.	5.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл цэсэнд байршуулсан. https://t.ly/Z1ptb https://t.ly/-l-yR https://t.ly/296pr	87.5
37.	5.10	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник,	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний мэдээлэл хариуцагчийн явуулж	87.5

		технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл	байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл цэсэнд байршуулсан. https://t.ly/DcVTs	
38.	5.13	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ цэсэнд байршуулсан. https://t.ly/oMVg_	87.5
39.	5.20	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал цэсний мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл цэсэнд байршуулсан. https://t.ly/Rs-lz	87.5
40.	5.21	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нүүр хуудсанд болон ил тод байдал цэсний авлигын эсрэг цэсний авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөө цэсэнд байршуулсан. https://t.ly/UNjJh https://t.ly/w9BRd	100
41.	5.22	Албан тушаалтны Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны ил тод байдал цэсний авлигын эсрэг цэсний авлигын эсрэг мэдээлэл цэсэнд байршуулсан. https://t.ly/zYugw	54.1
42.	5.23	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны ил тод байдал цэсний авлигын эсрэг цэсний ХАСУМ хянасан дүгнэлт цэсэнд байршуулсан. https://t.ly/UqTG6	75
43.	5.24	Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны ил тод байдал цэсний авлигын эсрэг цэсний чөлөөлөгдсөн албан хаагчдын нөөцийн бүртгэл байршуулсан. https://t.ly/BwQa_	75

		нөөцийн бүртгэл		
44.	5.25	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	Байгууллагын www.mmhi.gov.mn цахим хуудасны нээлттэй мэдээлэл цэсний нээлттэй өгөгдөл цэсэнд байршуулсан. https://t.ly/6Skr9	100

3.2. ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.8-д шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 03 дугаар сарын 01-ний дотор хүргүүлдэг.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/76 дугаар тушаалаар баталсан журмын дагуу УУХҮЯ-ны шилэн дансны мэдээлэл, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Мэдээллийг хуулийн хугацаанд мэдээ, мэдээллийг байршуулсан эсэх, мэдээллийг үнэн зөв, бүрэн, ил тод мэдээлсэн эсэхэд тухай бүр, сар, улирал тутам хяналт тавьж, системд тайлагнаж ажилласнаар хуулийн хэрэгжилт сайжирсан.

Сангийн яамнаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг 2024 оны жилийн эцсийн байдлаар **93.0** хувиар дүгнэгдсэн байна.

3.3. ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9.7-д заасны дагуу уг үзүүлэлтийг Авлигатай тэмцэх газар /АТГ/-аас гаргаж ЗГХЭГ-т хүргүүлдэг.

3.4. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд, Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсонтой холбоотойгоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.6-д “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар жил бүр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг бүх аймаг, нийслэлийг хамруулан хийх ажлыг зохион байгуулна, шаардагдах зардлыг төсөвт тусган батлуулсан байна. Захиргааны байгууллага салбарын болон орон нутгийн хэмжээнд бодлогын баримт бичгийн үр дүн, үр нөлөөг судлах, захиргааны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг хийж болно. Хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан ерөнхий удирдамжийг баримтлан хөндлөнгийн байгууллагыг судалгааны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын дундаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг харгалзан сонгон шалгаруулна” гэж заасны дагуу ЗГХЭГ-аас хэрэглэгчийн үнэлгээг нэгдсэн байдлаар хийлгэхээр шийдвэрлэсэн.

4. БУСАД ТАЙЛАН

4.

4.1. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1.4, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 21 аймаг, нийслэлийн засаг дарга нартай 2024 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтэд өгсөн үнэлгээг дараах хүснэгтээр харуулав. Ерөнхий үнэлгээ 78.1 хувьтай.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ**

№	Аймгийн нэр	Засаг даргын нэр	Заалтын тоо	Дүгнэсэн арга хэмжээний биелэлтийн хувь							Биелэлтийн хувь
				100	90	70	50	30	0	-	
1	Архангай	Б.Цэрэннадмид	35	10	3	3	5	2	2	10	71.6
2	Баян-Өлгий	Е.Зангар	39	11	11	7	7	1	-	2	80.0
3	Баянхонгор	Д.Мөнхсайхан	34	14	5	1	4	2	3	5	75.2
4	Булган	Д.Пүрэв-Очир	31	10	-	2	-	2	6	11	60.0
5	Говь-Алтай	Г.Чинбат	34	14	2	3	4	1	-	10	84.2
6	Говьсүмбэр	Т.Бат-Эрдэнэ	31	11	1	2	3	-	5	9	67.3
7	Дархан-Уул	Б.Азжаргал	34	20	4	4	3	-	-	3	90.0
8	Дорноговь	О.Батжаргал	42	16	6	9	7	1	-	3	80.8
9	Дорнод	Ш.Ёл	42	18	5	7	3	1	-	8	85.8
10	Дундговь	С.Мөнхчулуун	30	15	1	4	1	3	1	5	80.4
11	Завхан	Г.Өнөрбаяр	38	10	2	6	4	3	2	11	70.0
12	Орхон	Б.Зоригтбаяр	37	22	3	3	7	1	-	1	85.0
13	Өвөрхангай	О.Пүрэвдорж	40	16	1	6	6	3	3	5	71.4
14	Өмнөговь	Н.Энхбат	46	30	1	5	4	2	4	-	80.4
15	Сүхбаатар	М.Идэрбат	36	14	1	3	4	6	1	7	71.7
16	Сэлэнгэ	Н.Лхагвадорж	39	20	-	1	7	3	-	8	80.9
17	Төв	Л.Төмөрчөдөр	39	19	-	5	8	2	2	3	75.3
18	Увс	С.Батжаргал	38	12	5	6	7	-	-	8	80.6
19	Ховд	М.Амарсанаа	37	14	7	6	5	1	1	3	80.3
20	Хөвсгөл	П.Лхагважав	30	9	1	9	4	1	-	6	77.0
21	Хэнтий	Д.Аюурбунь	38	24	2	6	4	-	1	1	86.5
22	Улаанбаатар	Х.Нямбаатар	29	11	1	1	3	1	-	12	84.7

Үнэлгээний дүн	799	340	62	99	100	36	31	131	78.1
----------------	-----	-----	----	----	-----	----	----	-----	------

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах нийтлэг зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

1. Гэрээний заалтыг аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулж, тухайн орон нутгийн онцлогийг харгалзан, үр дүнд суурилсан байдлаар боловсруулаагүйгээс нийт 799 заалт бүхий гэрээнээс 131 заалт хэрэгжээгүй буюу үнэлэх боломжгүй, үнэлгээ хийгдээгүй байна. Тухайлбал, Архангай аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 10, Баян-Өлгий аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 2, Баянхонгор аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 5, Булган аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 11, Говь-Алтай аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 10, Говьсүмбэр аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 9, Дархан-Уул аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 3, Дорноговь аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 3, Дорнод аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 8, Дундговь аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 5, Завхан аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 11, Орхон аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 1, Өвөрхангай аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 5, Сүхбаатар аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 7, Сэлэнгэ аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 8, Төв аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 3, Увс аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 8, Ховд аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 3, Хөвсгөл аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 6, Хэнтий аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 1, Нийслэл аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний 12 заалт тус тус байна.

2. Гэрээнд тусгагдсан дараах арга хэмжээг орхигдуулсан байна.Тухайлбал: Баянхонгор аймаг гэрээний 3.2.2 “Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 295 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан Ашигт малтмал, газрын тосны газрын орон нутаг дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх”, Говьсүмбэр аймаг гэрээний 3.2.2 “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээ, хязгаарт нийцсэн шийдвэрийг гаргаж ажиллах, хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг авах”, Өвөрхангай аймаг гэрээний 3.2.3 “Өнгөрсөн хугацаанд нийгэм, ард түмний дунд бий болсон энэ салбарын болон уул уурхайн чиглэлийн гадаад хөрөнгө оруулагчдын талаарх буруу,ташаа, үндэслэлгүй ойлголт, мэдээллийг залруулах, хөрөнгө оруулагчдын нийгэмд болон улс орон, бүс нутгийн хөгжилд үзүүлж буй эдийн засгийн үр нөлөөг үнэлэх, таниулах энэ талын албан ёсны мэдээллийг түгээх, сурталчлах, ойлгуулах ажлыг тогтмол, үе шаттай хийж байх”, Төв аймаг гэрээний 3.2.3 “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан гэрээ бүрийг www.iltodgereee.mn эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд байршуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”, Ховд аймаг гэрээний 3.2.3 “Өнгөрсөн хугацаанд нийгэм, ард түмний дунд бий болсон энэ салбарын болон уул уурхайн чиглэлийн гадаад хөрөнгө оруулагчдын талаарх

буруу, ташаа, үндэслэлгүй ойлголт, мэдээллийг залруулах, хөрөнгө оруулагчдын нийгэмд болон улс орон, бүс нутгийн хөгжилд үзүүлж буй эдийн засгийн үр нөлөөг үнэлэх, таниулах энэ талын албан ёсны мэдээллийг түгээх, сурталчлах, ойлгуулах ажлыг тогтмол, үе шаттай хийж байх” арга хэмжээ тус тус байна.

3. Гэрээнд тусгагдаагүй дараах арга хэмжээг тайлагнасан байна. Тухайлбал: Булган аймаг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дэмжих, Засгийн газрын холбогдох тогтоолуудын хэрэгжилтийг хангах”, “Салбарын жендерийн талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2019-2026/-г сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах чиглэлээр хамтран ажиллах ажлыг аймаг, орон нутгийн хэмжээнд зохион байгуулах”, Говь-Алтай аймаг “Салбарын жендерийн талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2019-2026/-г сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах чиглэлээр хамтран ажиллах ажлыг аймаг, орон нутгийн хэмжээнд зохион байгуулах”, Говьсүмбэр аймаг “Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 04, 05, 06 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах”, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дэмжих, Засгийн газрын холбогдох тогтоолуудын хэрэгжилтийг хангах” арга хэмжээ тус тус байна.

4. Гэрээний хэрэгжилтийг Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралтын дагуу тайлагнадаггүй, суурь түвшинг тодорхойлох талаар тусгаагүй, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй Архангай аймаг, Баянхонгор аймаг, Говь-Алтай аймаг, Говьсүмбэр аймаг тус тус байна.

5. Гэрээний биелэлтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгын хамт ирүүлээгүй Баянхонгор аймаг, Булган аймаг, Говь-Алтай аймаг, Дорнод аймаг, Завхан аймаг, Орхон аймаг, Өвөрхангай аймаг, Сэлэнгэ аймаг тус тус байна.

6. Говьсүмбэр аймагт төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх улсын байцаагч томилогдоогүйтэй холбогдуулан гэрээний 3.2.1 “Төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх орон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтанд улсын байцаагчийн эрх олгуулах, сунгуулах цуцлахтай холбоотой асуудлыг Засаг дарга Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хандаж шийдвэрлүүлэх”, “Шийтгэлийн хуудсыг орон нутгийн Төрийн сангаас авч, зарцуулалтын тайланг тухай бүр гарган, тогтоосон журмын дагуу тооцоо хийж хэвших”, “Хяналт шалгалт хийх эрх бүхий улсын байцаагчийг ажиллах нөхцөл баталгаагаар хангах”, “Байгууллагын болон зөөврийн шатахуун түгээх станц, зөвшөөрөлгүй ашиглаж байгаа газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, түгээх байгууламжийн үйл ажиллагаанд хяналт тавьж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх” заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

4.2. ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 5 гадаадын зээл, тусламжийн төсөл 2024 онд хэрэгжсэн бөгөөд эдгээр төслүүд бүгд буцалтгүй тусламжаар, санамж бичиг болон гэрээний хүрээнд хэрэгжиж байна.

Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн төслийн хэрэгжилтийн үнэлгээгээр 2024 оны жилийн эцсийн байдлаар “тодорхой үр дүнд хүрсэн”- зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай (70-100 хувь) 3 төсөл, “эрчимжүүлэх шаардлагатай”- зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй,

удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай (30-70%) 2 төсөл байна.

ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Д/Д	Төслийн нэр	Зорилтын тоо	Үнэлгээ (хувь)						Хэрэгжилт (хувь)
			100	90	70	50	30	0	
1	“МУ-ын агаарын чанарыг сайжруулах эрчим хүчний нөөцийн чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх” төсөл	3		2	1				83.3%
2	“Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” төсөл	3		1	2				76.6%
3	“Цацраг идэвхт хаягдлын менежментийн нөөц бололцоог нэмэгдүүлэх” төсөл	2	2						100%
4	“Солонгос-Монголын хамтарсан ховор металлын судалгааны төв байгуулах” төсөл	4			1		3		40%
5	“Үл эвдэх сорилтын чадавхийг сайжруулах” төсөл	4					4		30%
Нийт дүн		16	2	3	4		7		60%

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд ХБНГУ-ын Эдийн засаг, Хамтын ажиллагаа, Хөгжлийн Холбооны Яамны буцалтгүй тусламж, БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламж, БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны эргэн төлөгдөхүй хөгжлийн дэмжлэг, Олон Улсын Атомын Энергийн Агентлагын буцалтгүй тусламжаар нийт 5 төсөл хэрэгжиж байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжсэн гадаадын зээл, тусламжийн 5 төслийн хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 60 хувьтай үнэлэгдэв.

4.3. УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх 9 төсөл байгаагаас уул уурхайн 6, хүнд үйлдвэрийн 2, газрын тосны 1 төсөл байна. Хөтөлбөрт тусгагдсан 9 төслийн 2024 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл **58.9 хувь**, санхүүжилтийн гүйцэтгэл **44.4 хувийн** биелэлттэй дүгнэгдэв.

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ
(2024 онд төлөвлөсөн ажил болон санхүүжилтийн гүйцэтгэлээр)

№	Төслийн нэр	Ажлын гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ	Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ
1	Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах	21.2%	90	25.1%	30
2	Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл.	9%	0	1.0%	0
3	Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэл, ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулах төсөл	95.0%	90	60.6%	70
4	Цагаансуваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах төсөл	69.0%	70	36.1%	50
5	Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл	5%	0	5.0%	0
6	Тавантолгойн нүүрсний бүлэг ордод технологийн шинэчлэл хийж, олборлолтыг төслийн хүчин чадалд хүргэх, нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах төсөл	90%	90	66.4%	70
7	Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	9%	0	20.9%	30
8	Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах төсөл	100%	100	53.4%	50
9	Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглах төсөл	90%	90	159.3%	100
Үнэлгээний дүн			58.9		44.4

“Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн тодорхой ажил хийгдсэн боловч зорилтот түвшиндээ хүрээгүй, зохион байгуулалт, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай, боловсруулалтын шатанд байгаа дараах төслүүд байна. Үүнд:

Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл:

Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр хэлэлцүүлж, АМГТГ-ын даргын “Техник эдийн засгийн үндэслэл бүртгэх тухай” 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Т/39 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авсан.

ТЭЗҮ-ээр хөрөнгө оруулалт өндөр гарсан, исэлдсэн хүдрийн нөөц багассан зэрэг шалтгааны улмаас Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ энэ төслийг цаашид хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзэж, цаашдын судалгааг үргэлжлүүлэн хийж байна.

Уг төсөлд гэрээний дагуу ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажилд нийт 1,584.78 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. 2024 онд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх ажилд 142.5 сая төгрөг, техник технологийн түвшний үнэлгээ хийх ажлыг тус тус гүйцэтгээд байна.

Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл:

Ажлын явцын хувьд ТЭЗҮ батлагдсан, нарийвчилсан зураг төсөл боловсруулах техникийн даалгавар боловсруулсан.

Үйлдвэрлэл, технологийн паркийн газрын хил заагийн эргэлтийн цэгийг тэмдэгжүүлж, солбицол тодорхойлсон, 1:500 масштабтай байрзүйн дэвсгэр зургийг боловсруулсан. Дэд бүтцийн хувьд авто зам барьж байгуулах ажлын явц 30%, төмөр зам барих ажлын явц 96%, зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтын ажил дууссан, туршилтын үйлдвэрийн бүх тоног төхөөрөмж, барилга угсралтын ажил 100%, үйлдвэрлэлийн туршилтын ажлыг дуусгаж 2024 оны 12 дугаар сард туршилтын эцсийн тайлан гаргахаар ажиллан АҮЭБЯ-ны ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх төсөл:

Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д даалгасан. Өмнөх судалгааны ажлын явцад хийгдсэн Хэвтээ ам-1, Хэвтээ ам-1а, Хэвтээ ам-2, Хэвтээ ам-3, Хэвтээ ам-4, Хэвтээ ам-5-уудыг ашиглах боломжийг хангах, нарийвчилсан хайгуулын ажил эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тендерүүдийг дахин зарлаж, 5 дугаар сарын 29-ны өдөр гүйцэтгэгч компани шалгарч 6-р сарын 10-ны өдөр гэрээ байгуулсан бөгөөд тус компани нь ордод хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 2024 оны байдлаар 9%-тай байна.

4.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны худалдан авах ажиллагаа 2024 оны жилийн эцсийн байдлаар 959,170.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төрлийн худалдан авалтад 875,926.2 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 83,244.2 мянган төгрөгийг хэмнэж зарцуулсан байна. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний

нийтлэг журам"-ын дагуу Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг гаргахад **95.8** оноогоор үнэлэгдэв.

1.1 Нээлттэй тендер шалгаруулалтаар:

- Мэдээлэл технологийн үйлчилгээ - 1 багцтай
- Урсгэл засвар-1 багцтай
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил-2 багцтай
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын 2023 оны нэгтгэл тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээ-1 багцтай

1.2 Тендер шалгаруулалтын онцгой журам "Харьцуулалтын арга"-аар:

- Багаж, техник хэрэгсэл
- Мэдээлэл технологийн үйлчилгээ
- Мэдээлэл сурталчилгаа
- Эмчилгээ, үйлчилгээ

1.3 Шууд худалдан авалт:

- Бичиг хэрэг
- Тээвэр шатахуун
- Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс
- Хөдөлмөр хамгаалалын үйлчилгээг авсан.

1.4 Худалдан авах ажиллагааны явцад тендерийн хүчинтэй хугацаанд тендерт оролцогчоос гомдол гараагүй.

Худалдан авах ажиллагааны цахим систем ашигласан талаар

Худалдан авалтыг 100 хувь цахим системээр зохион байгуулж ажилласан бөгөөд цахим худалдан авалт /ерөнхий гэрээ/-аар 1 нэр төрлийн 46.5 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан. Үүнд: мэдээллийн технологийн үйлчилгээ багтаж байна.

Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар

Ашигт малтмал, газрын тосны газрын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт **96.4** хувиар, Үндэсний геологийн албаны 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт **92.7**, Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт **98.0** хувиар тус тус үнэлэгдлээ.

Дүгнэлт

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны багцын худалдан авах ажиллагааны тайланг Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам"-ын дагуу үнэлэхэд худалдан авах ажиллагаа "тодорхой үр дүнд хүрсэн" буюу **95.7** хувийн биелэлттэй байна.

5. ДҮГНЭЛТ

Эрдэс баялгийн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 27 хувь, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 71 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 81, экспортын орлогын 94 хувь, улсын төсвийн орлогын 34 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Түүнчлэн Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжсанаас ашигт малтмалыг зах зээлийн бодит үнээр борлуулах, арилжааны болон гэрээ, хэлцэл ил тод болох, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид үнэн бодит мэдээллээр хангагдах, уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, албан татвар, төлбөр хураамжийг бодитой ногдуулах зэрэг эдийн засагт эерэг нөлөөллүүд гарч улмаар уул уурхайгаас орсон орлогоос иргэдэд ноогдол ашиг хүртээгээд байна.

Улсын төсвийн хөрөнгөөр Монгол орны нутаг дэвсгэрийн 47 хувьд 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд хамруулсны үр дүнд: 2023 онд мөнгө 3,085 кг, зэс 216.5 мян.тн, цайр 23.6 мян.тн, сурьма 19.5 мян.тн, вольфрам 12.5 мян.тн, молибден 13.8 мян.тн, никель 8.7 мян.тн, хар тугалга 17.0 мян.тн, хүнцэл 647.7 мян.тн, төмөр 5,825.5 мян.тн, мангани 53.4 мян.тн, өнгөлгөөний чулуу 30,000 м3, шавар 4,628.0 тэрбум тн, 2024 онд алт 2437 тн, мөнгө 293 тн, зэс 2411.9 мян.тн, цайр 20010 тн, гянтболд 3,6 тн, хайлуур жонш 58156 тн, висмут 7910 тн, берилл 1549 тн, хар тугалга 23004 тн, лити 382 тн, төмөр 3954,8 мян.тн, манган 1546,9 мян.тн, шатдаг занар 1 тэрбум тн баялгийг илрүүлэн үнэлгээ өгсөн.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөх, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цэгцэлж, олон нийтэд нээлттэй болгох зорилтын хүрээнд 2024 онд 45 талбайд сонгон шалгаруулалтыг зарласны үр дүнд 144,187 га талбай бүхий 42 тусгай зөвшөөрөл олгож, улсын төсөвт 34,8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэв.

Монгол орны хэмжээнд өнөөгийн байдлаар газрын тосны хайгуулын 10, уламжлалт бус газрын тосны хайгуулын 8, газрын тосны ашиглалтын 4 талбайд тус тус Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/-ний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа үргэлжилж байна. Үүнээс гадна БХГ байгуулах шатанд 2, Газрын тос боловсруулах үйлдвэрийн 1, гэрээлэгчгүй нийт 18 талбай байна. 2024 онд Засгийн газрын тогтоолоор газрын тосны хайгуулын 4, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 2, нийт 6 талбайд БХГ байгуулахаар тогтсон. Газрын тосны орлогоос улсын төсөвт 2024 онд нийт 237.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. 2024 оны байдлаар улсын хэмжээнд нийт 568725 тонн газрын тос олборлож, 552867 тонн тос экспортолсон.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны үйл ажиллагаа, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний нэгтгэсэн тайланд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, Салбарын нийгэм, эдийн засгийн үзүүлэлт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, Байгууллагын ил тод байдлын үнэлгээнд тулгуурлан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу үнэлэхэд байгууллагын 2024 оны үйл ажиллагааны үр дүнгийн биелэлт **84.98%**-тай, ерөнхий үнэлгээг **4.25** оноогоор үнэлэв.

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	78.2	0.6	4.25
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	69.6		
	3. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	72.66		
	4. Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	94.8		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	87.3	0.2	
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	98.6		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	93.7	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	-		
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		
Ерөнхий үнэлгээ:		84.98	1.0	

6. ЗӨВЛӨМЖ

Бодлогын зорилтын хэрэгжилтийн талаар:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх төлөвлөгөөний дагуу зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосныг хэрэгжүүлж ажиллах;
- Тодорхой зорилт, арга хэмжээний хүрээнд дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн, зарцуулсан хөрөнгийн талаар биелэлтийг бүрэн, тодорхой, оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах;
- Тайланг тогтсон хугацаанд бүрэн, үнэн зөв, шуурхай тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын/хуучин нэрээр/ 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн “Хэрэгжилтийг хангах, үр дүнг сайжруулах тухай” 03 дугаартай албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Төрийн захиргааны удирдлагын газраас хэрэгжилтийн тайланг дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой гаргуулах, холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгийн огноо, дугаарыг тодорхой бичих, тайлангийн чанар, утга найруулгыг хянах.
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг гаргахдаа зорилтот түвшин, хүрсэн түвшин, тухайн арга хэмжээтэй холбоотой гарсан шийдвэрийн талаар оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах;

Байгууллагын чиг үүргийн талаар:

- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, салбарын болон яамны 2024-2028 оны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан зорилго, зорилт түүний хүрээнд авч хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжихүйц, тодорхой, бодитой төлөвлөн тусгах;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго, зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсөл хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр дүнг оновчтой байдлаар тайлагнах, холбогдох баримт нотолгоог тухай бүр цуглуулж тайланд хавсаргах /холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр, тайлан хүлээн авсан тухай баримт, судалгааны тайланд хяналт тавьсан тухай баримт, санхүүгийн баримт болон албан бичгийн огноо г.м./;
- Төрийн захиргааны удирдлагын газраас хэрэгжилтийн тайланг дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж нэгтгэн боловсруулахдаа

тайлангийн чанар, утга найруулгыг хянах, тогтсон хугацаанд бүрэн, үнэн зөв, шуурхай тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх

Байгууллагын нээлттэй байдлын талаар:

1. Яамны цахим хуудсанд байршуулах мэдээллийг мэдээлэл хариуцагч нараас тухай бүр шаардан байгууллагын цахим хуудасны нээлттэй мэдээлэл хэсэгт нийтэлж тогтмол шинэчлэл хийж хэвших;
2. Яам болон салбарын үйл ажиллагаатай холбогдуулан зохион байгуулж буй ажлуудыг иргэд олон нийтэд ойлгомжтой, нээлттэй байдлаар түгээх.

7. ХАВСРАЛТ

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах үйл ажиллагааны биелэлт;
- Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлт;
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;
- Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг биелэлт

ХЯНАСАН:

ХШҮДАГ-ЫН ДАРГА

Б.ӨНӨМӨНХ

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ

Д.БАТНАЙРАМДАЛ

ХШҮ ХИЙЖ, ТАЙЛАН

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ

И.БАТТУЯА

ШИНЖЭЭЧ

Ц.ТЭМҮҮЖИН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТТУУЛ

МЭРГЭЖИЛТЭН

Т.НАРАНТУВШИН